| <b>5</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                           | <b>00.00</b>        | <b>880,000.00</b>     |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                                    | <b>00.00</b>        | <b>880,000.00</b>     |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>                                                 | <b>00.00</b>        | <b>880,000.00</b>     |
| 225106      | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                             | 00.00               | 880,000.00            |
| <b>6</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b> | <b>00.00</b>        | <b>-880,000.00</b>    |
| 25          | Санхүүгийн үйл ажиллагааны зардал                                          | 00.00               | 5,346.37              |
| 250005      | Төлсөн ногдол ашиг                                                         | 00.00               | 5,346.37              |
| <b>7</b>    | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                     | <b>00.00</b>        | <b>-5,346.37</b>      |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                           | <b>00.00</b>        | <b>10,845,823.53</b>  |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                   | <b>00.00</b>        | <b>10,845,823.53</b>  |

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Шинэ хөдөө хөгжил ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг захирал Ш.Өлзийхутаг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл,



анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд авлага өглөг барагдуулаагүй, татвар, нийгмийн даатгалын шимтгэл илүү шилжүүлсэн, өвс хүлээлцсэн акт үйлдээгүй зэрэг талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 25-наас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Төрийн аудитын газрын аудитор Б.Энхтөр хариуцаж хэрэгжүүлэв.

Шинэ хөдөө хөгжил ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлийн техник, технологийг иргэдэд түрээслэх болон эргэн төлөгдөх хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож иргэдийг өмчтэй болгох зорилготой, дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуйн салбарын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

Байгууллага тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Компани тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Иргэний тухай хууль
- МУЗЗНДНТУ тухай хууль

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Шинэ хөдөө хөгжил ОНӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт аудитын алба дотоод аудит, хяналт шалгалт хийсэн байна.

### **3.4. Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2 сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн зардлын 1251.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 25.02 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлант оны санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлт зардлын 191.4 сая төгрөгөөс 1 хувиар тооцож 1.9 сая төгрөгөөр тогтоолоо.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шинэ хөдөө хөгжил ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0 сая төгрөгөөр буюу 100 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт                                              | Эхний<br>үлдэгдэл | Эцсийн<br>үлдэгдэл   | Өөрчлөлт             |
|-------------------------------------------------------|-------------------|----------------------|----------------------|
| Б                                                     | 1                 | 2                    | 3=2-1                |
| Мөнгөн хөрөнгө                                        |                   | 10845823.53          | 10845823.53          |
| Авлага                                                |                   | 1259066261.03        | 1259066261.03        |
| Урьдчилгаа                                            |                   |                      |                      |
| Бараа материал                                        |                   | 45332700             | 45332700             |
| Үндсэн хөрөнгө                                        |                   | 2077011709.26        | 2077011709.26        |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                             |                   | <b>3392256493.82</b> | <b>3392256493.82</b> |
| Өр төлбөр                                             |                   | 450885.60            | 450885.60            |
| Эздийн өмч                                            |                   | 2226361400           | 2226361400           |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө<br/>өмчийн дүн</b> |                   | <b>3392256493.82</b> | <b>3392256493.82</b> |

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 10.8 сая төгрөг болж 10.8 сая төгрөгөөр өссөн нь авлага барагдуулсан шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө нэмэгдсэн байна.

Авлага дансны үлдэгдэл 1259.06 сая төгрөг болж 1259.06 сая төгрөгөөр өссөн нь эргэлтийн хөрөнгийг иргэдэд түрээслүүлж орлого олох шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2020 онд шинээр үүссэн, он удаан жил болсон хувь хүнээс авлага байхгүй байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 45.3 сая төгрөг болж 45.3 сая төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг, бусад хангамжийн материал болон тусгай зориулалтын материал шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 0.9 сая төгрөг, ХХААГ-раас үнэ төлбөргүй хүлээн авсан 534.2 сая төгрөгийн ХАА тоног төхөөрөмж, малын байр, үжлийн мал, сүү хөргөлтийн танк зэрэг хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд 2020 онд худалдаж авсан ашиглалтгүй 45.0 сая төгрөгийн гүн хөлдөөсөн хиймэл хээлтүүлгийн үр бараа материал байна. Энэ нь хөрөнгийн үр өгөөж муу байна.

Оны эцэст 15.9 сая төгрөгийн түлш шатахуун, сэлбэг хэрэгсэл, бичиг хэрэг, аж ахуйн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь үйл ажиллагааг хэвийн явуулахад ашигласан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2183.3 сая төгрөг болж 2183.3 сая төгрөгөөр өссөн нь байгууллага оршин тогтноход хөрөнгийн эх үүсвэр шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2182.4 сая, Шинэ хөдөө төсөл хөтөлбөрийн нэгжээс 2181.4 сая, Булган аймгийн Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1 сая, өөрийн хөрөнгөөр худалдан авсан 0.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө 0.9 сая төгрөг болж 0.9 сая төгрөгөөр өссөн нь санхүүгийн программ худалдан авсан шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.4 сая төгрөг болж 0.4 сая төгрөгөөр өссөн нь Татварт ХХОАТ дутуу шилжүүлсэн шалтгаалжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл 2226.4 сая төгрөг болж 2226.4 сая төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө орлогот авсан шалтгаалжээ. Үүнд:

- Төрийн өмчийн дансны үлдэгдэл 2226.4 сая төгрөг болж 2226.4 сая төгрөгөөр өссөн нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 41 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт үндэслэлээр нэмэгдүүлж бүртгэснээс шалтгаалсан байна.

Тайлант үеийн хуримтлагдсан ашиг 1165.4 сая төгрөг болж 1165.4 сая төгрөгөөр өссөн нь эргэлтийн хөрөнгийг авлагаар тусгасан шалтгаалжээ.

### 3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Шинэ хөдөө хөгжил ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Шинэ хөдөө хөгжил ОНӨААТҮГ-ын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 222.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 62.8 сая төгрөгөөр, ашиг 160.0 сая төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 96.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 86.1 сая төгрөгийн зардал гарган, 11.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь хүлэмж, Нөөцийн өвс бүрдүүлэлт, павильон, чацарганы орлогоос бүрджээ. Улсын төсвөөс 60.4 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 36.4 сая төгрөгийн орлого бүрдсэн байна.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

| № | Үзүүлэлт                             | Хэмжих нэгж | 2019 оны гүйцэтгэл | 2020 оны     |             | Зөрүү        | Хувь      |
|---|--------------------------------------|-------------|--------------------|--------------|-------------|--------------|-----------|
|   |                                      |             |                    | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл   |              |           |
| 1 | <b>Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт</b> |             |                    | <b>222.6</b> | <b>96.8</b> | <b>125.6</b> | <b>56</b> |
|   | Түрээсийн орлого                     |             |                    | 222.6        | 36.4        | 186          | 16        |
|   | Дотоод санхүүжилтийн орлого          |             |                    |              | 60.4        | 60.4         | -100      |
| 2 | <b>Нийт орлого</b>                   |             |                    |              |             |              |           |

|          |                                    |  |  |             |             |              |           |
|----------|------------------------------------|--|--|-------------|-------------|--------------|-----------|
|          | Үүнээс: Цэвэр борлуулалт           |  |  |             |             |              |           |
| <b>3</b> | <b>Нийт зардал</b>                 |  |  | <b>62.8</b> | <b>85.1</b> | <b>-22.3</b> | <b>36</b> |
|          | Үүнээс:                            |  |  |             |             |              |           |
|          | а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг |  |  |             |             |              |           |
|          | б) Ерөнхий ба удирдлагын зардал    |  |  | 56.6        | 34.8        | 21.8         | 38        |
|          | в) Хөрөнгө оруулалт их засвар      |  |  | 6.2         | 50.2        | -44.0        | -71       |
| <b>4</b> | <b>Цэвэр ашиг, алдагдал</b>        |  |  |             |             |              |           |
|          |                                    |  |  |             |             |              |           |

Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүдийн биелэлт, гүйцэтгэлийн шалтгаан нөхцөлийг үзүүлэлт бүрээр товч, тодорхой бичих.

Нийт орлогын гүйцэтгэл 96.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 125.6 сая төгрөг буюу 56 хувиар давж тасарсан нь чацаргана, хүлэмжийн түрээсийн орлого дутуу төлөгдсөн зэрэг шалтгаанаас голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 85.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 22.3 сая төгрөг буюу 36 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь төлөвлөгөөнд тусгагдаагүй нөөцийн өвс бэлтгэх санхүүжилт авсан гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 160 сая төгрөг болж, төлөвлөснөөс 150.0 сая төгрөгөөр дутуу байгаа нь чацаргана тариалалт муу байгаа тул иргэд түрээсийн төлбөрөө төлөөгүй 99.4 хувиар дутуу биелсэн, зардал 36 хувиар нэмэгдсэн тус тус шалтгаалж байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав. Орлого зарлагын төвлөрүүлэх төлөвлөгөө батлаагүй байна.

### 3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Аймгийн ТУЗ нь 9 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд 3 удаа зохион байгуулж 10 асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагаа, засаглалтай холбоотой журмыг шинээр боловсруулж, нийт 1 журмыг ТУЗ-ийн 2020 оны 03 дугаар тогтоолоор баталжээ.

### 3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээллээс 35 мэдээллийг хугацаанд нь, 0 мэдээллийн хугацаа болоогүй, 110 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийг байршуулаагүй байна.

### 3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шинэ хөдөө хөгжил ОНӨААТҮГ нь 2020 оны 04 дүгээр сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Иймд өмнөх онд санхүүгийн тайлан гаргаагүй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая.төг/

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |     | Биелэлт |     | Гүйцэтгэлийн хувь |
|-----------------|---------------------|-----|---------|-----|-------------------|
|                 | Тоо                 | Дүн | Тоо     | Дүн |                   |
| Акт             | 0                   | 0   | 0       | 0   | 0                 |
| Албан шаардлага | 0                   | 0   | 0       | 0   | 0                 |
| Зөвлөмж         | 0                   | 0   | 0       | 0   | 0                 |
| Нийт дүн        | 0                   | 0   | 0       | 0   | 0                 |

### 3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1307.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 46.09 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1261.01 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Залруулсан алдаа зөрчилгүй.

#### Төлбөрийн акт, албан шаардлага

1. Төлбөрийн акт тавигдаагүй.

### 3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Шинэ хөдөө-хөгжил ОНӨААТҮГ нь иргэдэд үржлийн мал, тоног төхөөрөмж түрээслэх болон эргэн төлөгдөх хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож иргэдийг өмчтэй болгох зорилготой ОНӨААТҮ-ны байгууллага юм. Тус байгууллагаас хэрэгжиж байгаа арга хэмжээгээр дамжуулан мал, тоног төхөөрөмж, хүлэмж худалдан авч байгаа боловч эргэн төлөгдөх хуваарийн дагуу иргэдээс төлбөр гүйцэд орж ирэхгүй авлага үүсч байна. Тайлант оноос үзэхэд хүлэмжийн төлбөр 9.6 сая төгрөг дутуу төлөгдсөн.

Шинэ хөдөө-хөгжил ОНӨААТҮГ нь дотоод хяналт ажиллаагүй тул өр авлага үүс ч тооллого болон тооллогоор хүлээн авсан гүн хөлдөөсөн үр зэрэг эргэлтийн хөрөнгийг тоо ширхгээр хүлээн аваагүй байна. Мөн Нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ-ыг илүү шилжүүлсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй, хяналтгүй тээвэр шатахуун зарцуулсан зэрэг алдаа зөрчил нь анхаарал татахуйц асуудал болоод байна.



#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Авлагын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: ХХОАТ-ын хөнгөлөлтийг 10 сараар бодох байсанг 12 сараар тооцож олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах заалтыг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:  
НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж  
Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах заалтыг хангаж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:  
Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

##### 2. Авлагын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэл илүү шилжүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах заалтыг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:  
НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

2.3. Өгсөн зөвлөмж:  
Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах заалтыг хангаж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:  
Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

##### 3. Орлогын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Хутаг-Өндөр сумын Цагаан булан дахь чацаргана талбайн худаг үзэх ажлаар явсан 59.5 мянган төгрөгийн шатахууныг нярвын тайланд орлого аваагүй байна.

3.2. Эрсдэл:  
НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж:  
Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дах заалт, 6.3.1, 6.3.2, 6.3.3 дах заалтыг хангаж ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:  
Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

##### 4. Анх шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Хадлан бэлтгэхэд Хувь хүнээс 630 л түлш худалдаж авсан зарлагдсан нотлох баримтгүй

**4.2. Эрсдэл:**

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

**4.3. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7 дах заалтыг хангаж ажиллах

**4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

***5. Анх шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал***

**5.1. Илрүүлэлт:** Өвс бэлтгэж аймгийн Нөөцийн газрын хашаанд буулгахад өгч авсан хүлээлцсэн акт үйлдээгүй

**5.2. Эрсдэл:**

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

**5.3. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7 дах заалтыг хангаж ажиллах

**5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

***6. Анх шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал***

**6.1. Илрүүлэлт:** Татварын хэлтэст ажилчидтай холбоотой 450.8 мянган төгрөг өглөгтэй байна

**6.2. Эрсдэл:**

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

**6.3. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах заалтыг хангаж ажиллах.

**6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

***7. Авлагын данстай холбоотой асуудал***

**7.1. Илрүүлэлт:** Тайлант онд үүссэн эргэлтийн хөрөнгө буюу чацарганы суулгац, Хашаа, дуслын усалгааны систем, хүлэмж 2020 онд эргэн төлөгдөх хуваарийн дагуу хийгдэх байсан боловч хийгдээгүй үлдэгдэл 9630.0 мянган төгрөг, услалтын систем, зөгийн бүлийн дагалдах хэрэгслийг иргэдэд түрээсээр олгож авлагаар бүртгэсэн байна.

**7.2. Эрсдэл:**

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

**7.3. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах заалтыг хангаж ажиллах.

**7.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

***8. Дотоод хяналттай холбоотой асуудал***

**8.1. Илрүүлэлт:**

Дотоод хяналтгүй тул тайлант онд дотоод хяналт хийгээгүй байна.

**8.2. Эрсдэл:**

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

**8.3. Өгсөн зөвлөмж:**

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг хэрэгжүүлж ажиллах

**8.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

**9. Шилэн данстай холбоотой асуудал**

**9.1. Илрүүлэлт:**

145 мэдээлэл оруулахаас 110 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн.

**9.2. Эрсдэл:**

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

**9.3. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дах заалтыг хангаж ажиллах

**9.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

|                              |                            |                                                                                   |                     |
|------------------------------|----------------------------|-----------------------------------------------------------------------------------|---------------------|
| Огноо:                       | Аудитын нэр:               | Шинэ хөдөө-хөгжил ОНӨААТҮГ 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит | Аудитын код:        |
| 2021                         |                            |                                                                                   | САГ-2021/6/СТА-ТӨҮГ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Шинэ хөдөө-Хөгжил ОНӨААТҮГ |                                                                                   | Сая төгрөг          |

| № | Алдаа, зөрчлийн товч утга                                                                                                                           | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны |                         |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|---------------------------------------|---------------------------------------------------|-------------------------|
|   |                                                                                                                                                     |            | Нэр                                   | Албан тушаал                                      | Овог нэр                |
|   | 1                                                                                                                                                   | 2          | 3                                     | 4                                                 | 5                       |
| 1 | ХХОАТ-ын хөнгөлөлтийг 10 сараар бодох байсныг 12 сараар тооцож олгосон.                                                                             | 89.9       | Зөвлөмж                               | Захирал нягтлан бодогч                            | Ш.Өлзийхутаг Д.Ганцэцэг |
| 2 | Нийгмийн даатгалын шимтгэл илүү шилжүүлсэн                                                                                                          | 78.3       | Зөвлөмж                               | Захирал нягтлан бодогч                            | Ш.Өлзийхутаг Д.Ганцэцэг |
| 3 | Хутаг-Өндөр сумын Цагаан булан дахь чацарганы талбайн худаг үзэх ажлаар явсан 59.5 мянган төгрөгийн шатахууныг нярвын тайланд орлого аваагүй байна. | 59.5       | Зөвлөмж                               | Захирал нягтлан бодогч                            | Ш.Өлзийхутаг Д.Ганцэцэг |

|            |                                                                                                                                                                                                                                                                                                                  |                  |                 |                        |                            |
|------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|-----------------|------------------------|----------------------------|
| 4          | Хадлан бэлтгэхэд Хувь хүнээс 630 л түлш худалдаж авсан зарлагдсан нотлох баримтгүй                                                                                                                                                                                                                               | 1272.6           | Зөвлөмж         | Захирал нягтлан бодогч | Ш.Өлзийхутаг<br>Д.Ганцэцэг |
| 5          | Өвс бэлтгэж аймгийн Нөөцийн газрын хашаанд буулгахад өгч авсан хүлээлцсэн акт үйлдээгүй                                                                                                                                                                                                                          | 0                | Зөвлөмж         | Захирал нягтлан бодогч | Ш.Өлзийхутаг<br>Д.Ганцэцэг |
| 6          | Татварын хэлтэст ажилчидтай холбоотой 450.8 мянган төгрөг өглөгтэй байна                                                                                                                                                                                                                                         | 450.8            | Зөвлөмж         | Захирал нягтлан бодогч | Ш.Өлзийхутаг<br>Д.Ганцэцэг |
| 7          | Тайлант онд үүссэн эргэлтийн хөрөнгө буюу чацарганы суулгац, Хашаа, дуслын усалгааны систем, хүлэмж 2020 онд эргэн төлөгдөх хуваарийн дагуу хийгдэх байсан боловч хийгдээгүй үлдэгдэл 9630.0 мянган төгрөг, услалтын систем, зөгийн бүлийн дагалдах хэрэгслийг иргэдэд түрээсээр олгож авлагаар бүртгэсэн байна. | 1259066.2        | Зөвлөмж         | Захирал нягтлан бодогч | Ш.Өлзийхутаг<br>Д.Ганцэцэг |
| 8          | Дотоод хяналтгүй тул тайлант онд дотоод хяналт хийгээгүй байна.                                                                                                                                                                                                                                                  | 0                | Зөвлөмж         | Захирал нягтлан бодогч | Ш.Өлзийхутаг<br>Д.Ганцэцэг |
| 9          | 145 мэдээлэл оруулахаас 110 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн                                                                                                                                                                                                                                                   | 0                | Зөвлөмж         | Захирал нягтлан бодогч | Ш.Өлзийхутаг<br>Д.Ганцэцэг |
| 10         | Замын хуудас, орлого зарлагын баримт байгаа боловч түлш шатахууны зарцуулалтын нотлох баримтгүй Е-баримт болон талоны үлдэх хувь байхгүй                                                                                                                                                                         | 1098.1           | Албан шаардлага | Захирал нягтлан бодогч | Ш.Өлзийхутаг<br>Д.Ганцэцэг |
| 11         | Гүн хөлдөөсөн үрийг 6000 ш гэж хүлээн авсан боловч хээлтүүлэгчийн хөлдөөсөн үрийг тоо ширхгээр тоолж хүлээн аваагүй                                                                                                                                                                                              | 45000            | Албан шаардлага | Захирал нягтлан бодогч | Ш.Өлзийхутаг<br>Д.Ганцэцэг |
| <b>ДҮН</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                  | <b>1307115.4</b> |                 |                        |                            |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Б.ЭНХТӨР